



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

"Сэлэнгэ Энерго" ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/007/-НА-СТА-ОНӨГ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Аудиторыг гүйцэтгэсэн: Пийк Ом Аудит ХХК Утас: 99052418	Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn Цахим хаяг: cheegii9989@gmail.com
---	---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах зөвлөл

Агуулга

1.Аудитын дүгнэлт	3-4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	7
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	8
3.Санхүүгийн тайлангийн тодруулга	9
3.1 Байгууллагын үйл ажиллагаа	
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	11
3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	
4. Аудитын тайлан.....	14
4.1. Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны мэдээлэл	15
4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 ЗАВСРЫН АУДИТЫН ТАЛААР.....	16
4.5.2 ӨМНӨХ АУДИТЫН МӨРӨӨР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮН	16
4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. Аудитын илрүүлэлт	16
5.1 Төлбөрийн акт	19
5.2 Албан шаардлага	
5.3 Зөвлөмж.....	
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	0



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

“СЭЛЭНГЭ ЭНЕРГО” ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Б.АЛТАНСҮХ ТАНАА

2025-03-24 № СЭА-2025/007/АМ-СЭМ-0185
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Сэлэнгэ Энержо” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол “Сэлэнгэ Энержо” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар дараах зөрчлүүд илэрсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 20 дугаар зүйлийн 20.1.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь заалтууд болон Сэлэнгэ аймгийн Засаг даргын баталсан “Сэлэнгэ энержо” ААТҮГ-ын 2024 оны санхүүгийн орлого, зарлагын нэгдсэн төлөвлөгөө”, “Сэлэнгэ Энержо ОНӨААТҮГ-ын 2023-2024 оны хамтын гэрээ”-ний холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Тайлант оны үйл ажиллагааны үр дүнгээр 432,780.2 мянган төгрөгийн алдагдал хүлээсэн нь өмнөх оныхоос 1,010,841.6 мянган төгрөгөөр буурсан хэдий ч өөрийгөө бүрэн санхүүжүүлэн ажиллаж чадаагүй,

- 2024 оны санхүүгийн төлөвлөгөөнд тусгагдсан гүйцэтгэх удирдлагын болон албан томилолт, шатахуун, харуул хамгаалалтын зардлыг 39,775.3 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан;
- Хамтын гэрээ болон дотоод журмын холбогдох заалтыг зөрчиж ажилтны удаан жилийн нэмэгдэлд 7,669.6 мянган төгрөг олгосон;
- Төлбөр тооцоог тухай бүр хянаагүйгээс улирлын шинж чанартай түр ажилтнуудад цалингийн урьдчилгаа олгосон боловч ажлаас чөлөөлөгдөхөд нь тооцоо хийгээгүйгээс цалингийн 1,402.8 мянган төгрөгийн авлага үүсгэсэн,
- 82,193.5 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй буюу хүчин төгөлдөр анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан.

Асуудлыг онцолсон хэсэг

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 3 дугаар зуухны шинэчлэлтийн ажилд 297,125.3 мянган төгрөг, дулааны станцын дээврийн засварт 94,813.6 мянган төгрөг, төв шугамын засварт 153,537.4 мянган төгрөг, 200квт зуухны насосны засварт 260,770.0 мянган төгрөг, төв шугамын засварт 20,000.0 мянган төгрөг, Сүхбаатар сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар төв шугамын засварт 20,000.0 мянган төгрөгийн зэрэг нийт 846,246.3 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд тус үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд дараах эерэг өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Орлогыг 9,187,681.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 10,748,466.6 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 10,107,461.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 10,540,241.9 мянган төгрөгийн зардал гаргаж, баталсан орлогын төлөвлөгөөг 919,780.7 мянган төгрөгөөр давуулан биелүүлж, зардлыг 208,224.7 мянган төгрөгөөр хэмнэсэн,
- Өмнөх оноос авлагын үлдэгдэл 193,457.3 мянган төгрөгөөр, өр төлбөр 244,966.5 мянган төгрөгөөр тус тус буурсан,
- Тайлант онд үйлдвэрлэлийн үр дүнгээр 432,780.2 мянган төгрөгийн алдагдал хүлээсэн буюу өмнөх оныхоос алдагдлыг 1,010,841.6 мянган төгрөгөөр бууруулсан гэх мэт.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын 2024 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 10 зорилтын хүрээнд 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		2024 оны 1 сарын 1	2024 оны 12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	6,585,632.36	2,110,125.24
1.1.02	Дансны авлага	1,455,246,168.51	1,264,366,098.05
1.1.04	Бусад авлага	4,291,712.00	1,771,083.55
1.1.06	Бараа материал	875,108,380.39	1,085,393,064.27
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	56,609.59	0.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,341,288,502.85	2,353,640,371.11
1.2.01	Үндсэн хөрөнгө	13,717,349,048.35	14,018,484,650.47
1.2.02	Биет бус хөрөнгө	14,010,000.00	10,950,000.00
1.2.08	Бусад эргэлтийн бус хөрөнгө	568,520,400.00	608,708,400.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	14,299,879,448.35	14,638,143,050.47
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	16,641,167,951.20	16,991,783,421.58
2.1.1.01	Дансны өглөг	3,766,684,477.31	2,615,918,364.39
2.1.1.02	Цалингийн өглөг	151,852,787.00	198,674,403.23
2.1.1.03	Татварын өр	3,084,713,057.42	3,652,542,824.89
2.1.1.04	НДШ - ийн өглөг	2,141,315,702.72	2,597,796,193.18
2.1.1.06	Хүүний өглөг	43,294,124.23	0.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	9,187,860,148.68	9,064,931,785.69
2.1.2.01	Урт хугацаат зээл	161,737,822.43	39,699,662.53
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	161,737,822.43	39,699,662.53
2.2	Өр төлбөрийн нийт дүн	9,349,597,971.11	9,104,631,448.22
2.3.01	Өмч: - төрийн	11,576,804,189.48	12,575,644,758.87
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	8,736,940,966.15	8,736,940,966.15
2.3.09	Хуримтлагдсан ашиг	-13,022,175,175.54	-13,425,433,751.66
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	-432,780,183.82
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	-13,022,175,175.54	-12,992,653,567.84
2.3.11	Эздийн өмчийн дүн	7,291,569,980.09	7,887,151,973.36
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	16,641,167,951.20	16,991,783,421.58

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	5,445,254,653.48	7,359,368,758.06
02	Борлуулалтын өртөг	8,529,670,307.44	9,694,416,212.54
03	Нийт ашиг(алдагдал)	-3,084,415,653.96	-2,335,047,454.48
04	Түрээсийн орлого	0.00	0.00
05	Хүүний орлого	120,515.97	249,948.16
06	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
07	Эрхийн шимтгэлийн орлого	28,363,636.08	41,800,000.02
08	Бусад орлого	2,208,863,239.68	2,706,042,998.29
08.1	Орлогын дүн	2,237,347,391.73	2,748,092,946.47

10	Ерөнхий ба удирдлагын зардал	599,426,020.04	845,825,675.81
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	0.00	0.00
12.1	Зардлын дүн	599,426,020.04	845,825,675.81
17	Бусад ашиг (алдагдал)	2,872,431.00	0.00
17.1	Олз, гарзын дүн	2,872,431.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	-1,443,621,851.27	-432,780,183.82
19	Орлогын татварын зардал	0.00	0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-1,443,621,851.27	-432,780,183.82
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-1,443,621,851.27	-432,780,183.82

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
09	2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	11,576,804,189.48	8,736,940,966.15	-13,022,175,175.54	7,291,569,980.09
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	29,521,607.70	29,521,607.70
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	-432,780,183.82	-432,780,183.82
14	Өмчид гарсан өөрчлөлт	998,840,569.39	0.00	0.00	998,840,569.39
17	2024 оны 12 сарын 31-р үлдэгдэл	12,575,644,758.87	8,736,940,966.15	-13,425,433,751.66	7,887,151,973.36

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	7,898,782,222.21	10,734,053,404.18
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	5,452,294,521.21	7,753,091,096.25
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	31,200,000.00	44,780,000.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	2,393,861,300.00	2,900,000,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	21,426,401.00	36,182,307.93
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	7,721,255,039.39	10,566,121,717.76
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,044,311,739.01	2,628,459,181.52
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	111,714,127.00	274,342,418.68
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	2,648,969,455.00	3,931,290,946.35
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	973,949,860.63	2,020,209,316.67
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,513,073,008.90	1,366,604,613.30
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	62,808,849.17	44,723,146.40
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	227,342,159.68	285,018,359.39
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	2,299,575.00	5,197,300.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	136,786,265.00	10,276,435.45
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	177,527,182.82	167,931,686.42
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	120,515.97	249,948.16
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	120,515.97	249,948.16
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	77,513,600.00	50,618,981.80
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	60,983,600.00	50,618,981.80
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	16,530,000.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-77,393,084.03	-50,369,033.64
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	33,000,000.00	1,564,781,123.12
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	33,000,000.00	1,564,781,123.12
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	137,109,616.41	1,686,819,283.02
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	136,553,616.41	1,686,819,283.02
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-104,109,616.41	-122,038,159.90
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-3,975,517.62	-4,475,507.12
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,561,149.98	6,585,632.36
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,585,632.36	2,110,125.24

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Борлуулалтын орлого	м/төг	7,285,307,000.00	7,359,368,758.06	74,061,758.06	101%
2	Бусад орлого	м/төг	102,374,000.00	111,729,310.09	9,355,310.09	109%
3	Орон нутгийн татаас	м/төг	1,800,000,000.00	2,636,363,636.38	836,363,636.38	146%
2	Нийт орлого	м/төг	9,187,681,000.00	10,107,461,704.53	919,780,704.53	110%
3	Нийт зардал	м/төг	10,748,466,600.00	10,540,241,888.35	(208,226.00)	98%
	Үүнээс: Удирдлагын зардал	м/төг	142,693,000.00	158,434,376.41	15,741,376.41	111%
4	Татварын өмнөх ашиг	м/төг	(1,560,785,600.00)	(432,780,183.82)	1,128,005,416.18	28%
5	Цэвэр ашиг /алдагдал /	м/төг	(1,560,785,600.00)	(432,780,183.82)	1,128,005,416.18	28%
6	Төсвийн төлбөр	м/төг	2,667,166,000.00	2,662,136.00	(5,040.00)	0%

	а/Орлогын татвар	м/төг			-	
	б/НӨАТ	м/төг	1,560,000,000.00	1,572,428,805.43	12,428,805.43	101%
	в/НДШ	м/төг	784,000,000.00	783,051,401.14	(948,598.86)	100%
	г/ХАОАТ	м/төг	265,000,000.00	263,794,822.98	(1,205,177.02)	100%
	д/ҮХЭХАТ	м/төг	25,701,000.00	10,040,080.00	(15,660,920.00)	39%
	е/Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	м/төг	665,000.00	313,400.00	(351,600.00)	47%
	ё/Бусад татвар	м/төг	10,245,000.00	10,245,370.00	370.00	100%
7	Нийт ажиллагсдын тоо	Хүн	128	119.00	(9.00)	93%
8	Нийт цалингийн сан	м/төг	3,279,477,000	3,151,592.00	(127,884.00)	0%
9	Нэг ажиллагчийн дундаж цалин	м/төг	2,135,076	2,207.00	71,9	0%
10	Борлуулалтын орлогын 1 төг ногдох зардал	м/төг	0,85	0,96	0,1	
11	Хөрөнгө оруулалт	м/төг	512,600,000.00	463,700,000.00	(48,900,000.00)	90%
12	Нийт авлага	м/төг	1,459,537,880.51	1,266,137,181.60	(193,400,698.91)	87%
	Үүнээс: найдваргүй	м/төг			-	
13	Нийт өглөг	м/төг	9,349,597,970.80	9,104,631,448.22	(244,966,522.58)	97%
	Богино хугацаат өглөг	м/төг	9,187,860,148.37	9,064,931,785.69	(122,928,362.68)	99%
	Урт хугацаат өглөг	м/төг	161,737,822.43	39,699,662.53	(122,038,159.90)	25%

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ нь “Байгаль орчинд ээлтэй, хэмнэлттэй үр ашигтай технологи ашиглан хэрэглэгчдийн тав тухтай ажиллаж, амьдрах орчныг бүрдүүлж дулааны эрчим хүчээр жигд тасралтгүй найдвартай ханган ажиллах” гэсэн үндсэн чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын дүрэмд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Дулааны эрчим хүч үйлдвэрлэх, борлуулах,
- Гадаад дотоод худалдаа,
- Туслах үйлдвэрлэл хөгжүүлэх,
- Гуанз цайны газрын үйлчилгээ,

Тус ОНӨААТҮГ нь 2024 онд ЭХЗХ-ны “Дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах зөвшөөрлийн үйлчлэл” хүрээнд Сүхбаатар суманд КЕВ-25/14 маркийн 2 зуухаар, КВТС-20/150 маркийн 2 нийт 4 зуухаар дулааныг үйлдвэрлэн дулаан түгээж, жилд 44.2 мян.тн нүүрс, 4.27 сая.квт/ц цахилгаан эрчим хүч, 85.0 мян.м ус хэрэглэж, 108.8 мян.Гкал дулаан үйлдвэрлэж, нийт 335 албан байгууллага, ААН, 53 төсвийн байгууллага, 3,019 айл өрхөд 102.1 мян.Гкал дулааны эрчим хүч түгээсэн байна.

Тайлант онд 32 айл өрх , 8 аж ахуйн нэгж байгууллагыг дулааны шугамд холбон дулаанаар хангаж 55,999.1 мянган төгрөгийн борлуулалт хийсэн байна. Төмөр замын төвлөрсөн 3 орон сууц, аймгийн 19 төвлөрсөн орон сууцны коридорын хэсэг дулааны төлбөр төлөх хэмжээнд хамрагдаагүй байсныг хэмжилт хийн дулаан хэрэглэсэн төлбөр тооцоог тооцон авсанаар 15,978.9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэн ажилласан байна.

Тайлант онд захирлын 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн А/071 тоот тушаалаар 2023 онд үүссэн 3,772.5 мянган төгрөгийн, 2024 онд үүссэн 6,101.9 мянган төгрөгийн нийт 9,874.4 төгрөгийн борлуулалтын хөнгөлөлт буцаалт хийсэн байна.

Тайлант онд тоолуурын баталгаажуулалтын хугацаа дуусан, зөрчилтэй байсан 12 төсөвт байгууллагын дулаан хэмжих тоолуурыг баталгаажуулан ажиллажээ.

Тус үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал буюу төлөөлөн хэрэгжүүлэгч нь аймгийн Засаг дарга байх бөгөөд 100 хувь орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ нь аймгийн ИТХ-ын 2002 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 60 дугаар тогтоолоор байгуулагдсан байна. Энэ нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь “*Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулж болно.*”, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “*Аймгийн чиг үүрэгт дараах асуудал хамаарна:*”, 21.1.15 дахь “*харилцаа холбоо, цахилгаан, дулаан түгээх сүлжээ, цэвэр ус, бохир усны шугам болон хаягдал ус зайлуулах байгууламж, үерийн далан, суваг тэдгээрт хамааралтай барилга байгууламжийн төлөвлөлт, ашиглалт, хяналт*” Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь “*Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:...* 4/ **Орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих**” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын ерөнхий хууль
- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05, 08 дугаар сарын 30-нд нэмэлт өөрчлөлт орсон, гэх мэт.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц гэж үнэлсэн.

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ” нь 2021 онд боловсруулагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Нийт хөрөнгө өмнөх оноос 350,615.5 мянган төгрөгөөр буюу 2.1 хувиар өссөн нь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансанд материаллаг өөрчлөлт гарснаас шалтгаалсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6,585.6	2,110.1	-4,475.5
Авлага	1,459,594.5	1,266,137.2	-193,457.3
Бараа материал	875,108.4	1,085,393.1	210,284.7
Үндсэн хөрөнгө	14,299,879.4	14,638,143.0	338,263.6
Нийт хөрөнгийн дүн	16,641,167.9	16,991,783.4	350,615.5
Өр төлбөр	9,349,597.9	9,104,631.4	-244,966.5
Эздийн өмч	7,291,570.0	7,887,152.0	595,582.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	16,641,167.9	16,991,783.4	350,615.5

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 4,475.5 мянган төгрөгөөр буурсан нь 12,299,084.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 12,303,559.9 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.

- Авлага дансны үлдэгдэл 1,266,137.2 мянган төгрөг болж 193,457.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 15,804.8 мянган төгрөгийн авлага шинээр үүсч оны эхний үлдэгдлээс 171,399.8 мянган төгрөгийн, тайлант оны авлагаас 37,862.3 мянган төгрөгийн нийт 209,262.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулсантай холбоотой байна. Нийт авлагын 59.0 хувийг буюу 747,860.7 мянган төгрөгийг төсөвт байгууллагын, 26.5 хувийг буюу 335,996.7 мянган төгрөгийг ААН-ийн, аж ахуйн нэгж байгууллагын, 14.4 хувийг буюу 180,508.8 мянган төгрөгийг төвлөрсөн орон сууцны айл өрхийн, 0.1 хувийг буюу 1,771.0 мянган төгрөгийг ажиллагсадаас авах авлага тус тус эзэлж байна.
- Бараа материал дансны үлдэгдэл 1,085,393.1 мянган төгрөг болж 210,284.7 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн УБХ-ээс 7,360.2 мянган төгрөгийн амны маск, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, Сүхбаатар сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 108,000.0 мянган төгрөгийн дулааны станцын цахилгааны шугамын хос тэжээл зэрэг нийт 115,360.2 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй орлогоор хүлээн авч, өөрийн хөрөнгөөр 3,144,842.1 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч үйл ажиллагаандаа 3,049,917.6 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 17,994,011.9 мянган төгрөг болж 869,709.5 мянган төгрөгөөр өссөн нь дараах ажил,гүйлгээнээс шалтгаалсан байна. Үүнд:
 - Өөрийн хөрөнгөөр 62,463.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан,
 - Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 3 дугаар зуухны шинэчлэлтийн ажлыг 297,125.3 мянган төгрөгөөр, дулааны станцын дээврийн засварт 94,813.6 мянган төгрөг, төв шугамын засварт 153,537.4 мянган төгрөг, 200квт зуухны насосны засварт 260,770.0 мянган төгрөг, төв шугамын засварт 20,000.0 мянган төгрөгийн ажил гүйцэтгэсэн,
 - Сүхбаатар сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар төв шугамын засварт 20,000.0 мянган төгрөг зарцуулсан,
 - Аймгийн ИТХурлын 2024 оны 4 дүгээр сарын 01-ны өдрийн 160 тоот тогтоолоор ОНӨГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 4,406.1 сая төгрөгийн тавилга хэрэгсэлийг баланаас балансад шилжүүлж бүртгэсэн,
 - Аймгийн ГХБХБГ-аар хянан баталгаажуулалт, хэмжилт хийлгэж 3,349 м2 талбай бүхий 5 газрыг “Арвижих -Эсмитэйт үнэлгээ” ХХК аар үнэлгээ хийлгэн газрыг 40,188.0 сая төгрөгөөр үнэлүүлж, орлого авсан,
 - Аймгийн ИТХ-ын 2024 оны 158 дугаар тогтоолоор цаашид ашиглагдах боломжгүй нийт 83,594.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж дансаас хассан,

Өр төлбөр дансны үлдэгдэл 9,104,631.4 мянган төгрөг болж 244,966.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 11,317,090.2 мянган төгрөгийн өр төлбөр шинээр үүсч оны эхний үлдэгдлээс 1,314,632.9 мянган төгрөг, шинээр үүссэн өр төлбөрийг 10,247,423.8 мянган төгрөгөөр нийт 11,562,056.7 мянган төгрөгөөр барагдуулсантай холбоотой байна. Нийт өр төлбөрийн 28.5 хувь буюу 2,588,676.56 мянган төгрөгийг бэлтгэн нийлүүлэгч байгууллагын, 40.1 хувийг буюу 3,652,542.8 мянган төгрөгийг татварын, 28.5 хувь буюу 2,597,796.2 мянган төгрөгийг НДШ-ийн, 0.4 хувь буюу 39,699.7 мянган төгрөгийг урт хугацаат буюу хөрөнгө оруулалтын зээлийн, 2.2 хувь

буюу 198,674.4 мянган төгрөгийг цалингийн , 0.3 хувь буюу 27,241.7 мянган төгрөгийг илүү төвлөрүүлсэн дулааны өглөг тус тус эзэлж байна.

3.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилто түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 болон 20 дугаар зүйлийн 20.3-д заасны дагуу “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, холбогдох байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын даргын 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/09 дугаар тушаалаар 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталж, аймгийн Засаг дарга 2024 оны 02 дугаар 01-ний өдөр хянаж, баталгаажуулсан байна.

Тайлант оны нийт орлогыг 9,187,681.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 10,748,466.6 мянган төгрөгөөр тогтоож 1,560,785.6 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн байна. Аймаг, сумын хөрөнгө оруулалт болон өөрийн эх үүсвэрээр хийх хөрөнгө оруулалтын 4 арга хэмжээг нийт 512,600.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 10,107,461.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 10,540,241.9 мянган төгрөгийн зардал гарган, 432,780.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Жил бүр алдагдалтай ажиллаж өөрөө өөрийгөө санхүүжүүлж ажиллаж чадахгүй байгаа нь тайлант онд 1 Гкал дулааныг 100.5 мянган төгрөгөөр үйлдвэрлэж, 70.3 мянган төгрөгөөр худалдан борлуулж 1 Гкал дулаан тутамд 30.2 мянган төгрөгийн алдагдал хүлээн ажиллаж байгаагаас шалтгаалжээ.

2024 онд дулаан, хэрэглээний халуун усны орлого 7,359,368.7 мянган төгрөг, улсын төсвийн татаас санхүүжилтийн орлого 2,636,363.6 мянган төгрөг, нүүрс борлуулсны орлого 13,581.8 мянган төгрөг, техникийн нөхцөл болон бусад үйлчилгээний орлого 41,800.0 мянган төгрөг, хүү торгуулийн орлого, бусад үйлчилгээний орлого 56,097.7 харилцах дансны хүүгийн орлого 249.9 мянган төгрөгийн зэрэг нийт 10,107,461.7 мянган төгрөгийн орлогыг тус тус бүрдүүлжээ.

Нийт орлогын гүйцэтгэл 10,107,461.7 мянган төгрөг болж 919,780.7 мянган төгрөгөөр буюу 10.0 хувиар өссөн нь урьд оны дулааны авлага барагдуулсан, мөн ЭХЗХорооноос эрчим хүчний өр авлагыг өсгөхгүй байх, барагдуулах , санхүүгийн зохистой харьцааг хангаж ажиллах ажлын хүрээнд цахилгаан эрчим хүчний төлбөр, нүүрсний төлбөрт санхүүгийн дэмжлэг өгч ажилласан зэрэг хүчин зүйлүүд нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 10,540,241.9 мянган төгрөг болж төлөвлөснөөс 208,226.0 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь удирдлагын зардал 15,741.4 мянган төгрөгөөр, шатахууны зардал 22,749.2 мянган төгрөгөөр, тогтмол зардал 166,045.9 мянган төгрөгөөр, бусад бараа үйлчилгээний зардал 315,164.2 мянган төгрөгөөр нийт 519,700.7 мянган төгрөгөөр хэтэрч, бусад зардал 727,926.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу дараах 3 худалдан авах ажиллагааг tender.gov.mn цахим сайтаар нээлттэй зарласан байна. Үүнд:

- 108,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Дулааны станцын цахилгааны хос тэжээл худалдан авах”,
- 250,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Шатахуун нийлүүлэгчийг сонгон шалгаруулах”,
- 40,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Мах ханган нийлүүлэгчийг сонгон шалгаруулах”,

Худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг харьцуулалтын болон нээлттэй тендер шалгаруулалтын аргаар сонгон шалгаруулж, “Цогт Онон” ХХК, “НИК” ХХК, иргэн Ж.Оюундэлгэртэй “Худалдах, худалдан авах гэрээ” байгуулан ажилласан байна. Тайлант онд нүүрс бэлтгэн нийлүүлэгч компаниудад өртэй учраас нийлүүлэлт зогссон бөгөөд Багануур ХХК-тай шууд гэрээ байгуулж 443.0 тн буюу 2,171,611.0 мянган төгрөгийн нүүрсийг зээлээр худалдан авсан байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж, аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн санхүүгийн тайлан дахь хуримтлагдсан алдагдал, худалдан авалтыг төлбөрийн цахим баримтаар баталгаажуулах, авлага, татварын өр төлбөртэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Пийк Ом Аудит” ХХК-ийн аудитор Б.Наранчимэг гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 01/36 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материалаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 9,129,096.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу **91,290.9** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Хэвлэл захиалга хийгээгүй, сургалтыг цахимаар зохион байгуулсан,
- Ажилчдын утасны зардлын хэмжээг бууруулсан,
- Шинэ жилийн арга хэмжээг хийгээгүй, гарын бэлэг олгоогүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлд тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

“Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ нь тайлант хугацаанд шилэн дансанд мэдээлбэл зохих 152 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Пийк Ом аудит” ХХК нь 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 920 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” захидлыг тус байгууллагад хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар цалин илүү олгосон 236.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, авлага өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, анхан шатны баримтын бүрдэлийг ханган ажиллах, баталсан төлөвлөгөөг биелүүлж ажиллах зэрэг 1,146,744.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ төлбөрийн цахим баримтыг бүрдүүлэх, ХХОАТ-ын болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах зэрэг 120,631.8 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгөгдснөөс 3 зөвлөмжийг /худалдан авалтыг ө баримтаар баталгаажуулаагүй зөрчлийг давтан гаргасан/ хэрэгжүүлснээр аудитын шийдвэрийн хэрэгжилт 87.5 хувьтай байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	236.0	1	236.0	100.0
Албан шаардлага	3	1,146,744.5	3	1,146,744.5	100.0
Зөвлөмж	4	120,631.8	3	38,438.4	75.0
Нийт дүн	8	1,267,612.3	7	1,267,612.3	87.5

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргасан тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал

